

Хурлын протокол : Хувьцаа эзэмшигчдийн хурал

Өдөр : 2015.04.13

Хурал эхэлсэн цаг : 14:30

Хурал болсон газар : Чингис хааны морьт хөшөөт цогцолборт

Хурлын комисс : Ж.Баттөр, Б.Лхагвадорж, Д.Даянбилгүүн, Б. Намуун, Н. Уранчимэг, Б.Жавхаа

Хурлын ирц : Нийт хувьцааны **74.65 %** буюу **59,710,914** ширхэг хувьцаа эзэмшиж буй 150 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэй хуралдсан.

Хурлын даргын овог нэр : Б.Лхагвадорж

Хурлаар хэлэлцсэн асуудал :

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-н гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компаний ногдол ашиг хувиарлах тухай
3. Компаний үйл ажиллагааны төлөвлөгөө
4. ТУЗ – н гишүүдийг сонгох

Хурлын тэмдэглэл :

Хурлын эхэнд хурлын дарга Д.Лхагвадорж ХЭХ –н ирцийг тооллогын комиссын тайлангын дагуу танилцууллаа, мөн хурлын дэг болон саналын хуудас тараах материалын талаар тайлбар хийлээ.

Хурлын дарга Д.Лхагвадорж хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулж хурлыг нээлээ.

Хурлын дарга Д.Лхагвадорж

Та бүхэнд “Женко Түр Бюро” ХК –н 2014 оны үйл ажилгаа болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-н дүгнэлтийг ерөнхийд нь танилцуулья , 2014 оны тайлант хугацаанд нийт 3,06 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, цэвэр ашиг 23,4 сая төгрөгийн цэвэр ашгийн хувьтай ажилалаа. Өмнөх онтой харьцуулахад борлуулалтын орлого 7,6 хувиар өссөн үзүүлэлттэй байна

Аудитын хорооны гишүүн Д.Даянбилгүүн

Сайн байцгаана уу? 2012 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангын талаар аудитын хорооны дүгнэлтийг танилцуулья. 2014 онд “Женко түр бюро” ХК-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилалаа. Бид Компанийн тухай хууль, хувьцаат компанийн дүрмийг удирдлага болгон хяналт шалгалт хийх эрх үүргийнхээ дагуу, тус компанийн үйл ажиллагаанд ээлжит шалгалтыг явуулсан. Шалгалтыг компанийн ТУЗ-ийн хурлаас гаргасан шийдвэрийн биелэлт, санхүүгийн тайлан, эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, зарцуулалт, хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийн хэрэгжилтийг албан ёсны бичиг баримтад тулгуурлан шалгаж, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргалаа.

Компанийн ажлын ажлийн тайлан болон төлөвлөгөөний талаар Гүйцэтгэх захирал Б.Намуун дэлгэрэнгүй тайлбар хийлээ.

Үүнд: Сайн байцгаана уу?

Бид 2014 онд давхардсан тоогоор нийт 144 мянга гаруй гадаад, дотоодын жуулчдад Чингис хааны хөшөөт цогцолбор, XIII зуун цогцолбороороо болон Монголын унаган байгалийн үзэсгэлэнт газруудаар гадаадын иргэдийг аялуулах дотоод аялал жуулчлал, аялал жуулчлал хөгжсөн гадаад улс орнуудын дэлхийд алдартай газруудаар монгол иргэдэд гадаад аялал жуулчлалын үйлчилгээг үзүүлжээ.

“Чингис хааны морьт хөшөөт цогцолбор”-ын хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор

2013.05.14-ний өдөр 694.5 мянган ам.долларын, сарын1 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай зээл,

2014.07.09-ний өдөр 510.0 сая төгрөгийн, сарын 1,9 хувийн хүүтэй, 4 жилийн хугацаатай зээлүүдийг тус тус авч зээлийн гэрээний хуваарийн дагуу хугацаанд нь төлж байна.

Тайлан хугацаанд улирал, жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгэж, хөндлөнгийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан болно.

Бид 2015 ондоо Монгол Улсын аялал жуулчлалын салбарын хөгжилд хувь нэмэр оруулах, түлхэц болох, аялал жуулчлалын түгээлтийн сувгуудыг нэмэгдүүлэх мөн нийгмийн ашгийн тулд бүтээгдэхүүний чанар, хэрэглэгч үйлчлүүлэгчийг чанартай мэдээлэлээр хангах, үйлчилгээний үндсэн менежмент, урлаг спортын арга хэмжээг зохион байгуулах, маркетинг холбоо харилцаагаар дамжуулан жил дамнасан жуулчдын сэтгэл ханамжийн баталгааг өөрийн үйл ажиллагааны стандартыг дээшлүүлэхийн зэрэгцээ давхар бий болгох.

Хэтийн зорилт :Нийгэмд болон Монгол дахь аялал жуулчлалын салбарын хөгжилд түлхэц болохын тулд идэвхжүүлэл үр дүнтэй бодлого төлөвлөлт, зохион байгуулалт, судалгаа, мэдээлэл холбоохангамж, аялалын дэд бүтэц/аялал боловсруулах, чанартай бүтээгдэхүүний бодлого бизнесийн салбарын бодлого болон борлуулалт үйлчилгээний хэм хэмжээ гэх мэт арга барилыг ашиглан жил дамнасан жуулчдын сэтгэл ханамжийн баталгааг бий болгохоор ажиллах болно.

Хурлын дарга Б.Лхагвадорж

Та бүхэн асуулт, санал хүсэлт байвал хүсэлтээ мэдэгдээд микрофон аваад санал аа хэлнэ үү?

Иргэн 1/ н. Бор

- 1. Том хувьцаа эзэмшигчид гэж хэд байдаг хэдэн хувийг эзэлдэг вэ? мөн жижиг хувьцаа эзэмшигч нь хэд байгаа вэ?
- 2. Ноогдол ашгийг өнгөрсөн жил яагаад ТТХТ-р тараагаагүй вэ?

ТУЗ гишүүн Б.лхагвадорж

ТТХТ-ийн ноогдол ашиг тараах үйлчилгээний хөлс нэмэгдсэн учраас бид өөрийн компаниар дамжуулан ногдол ашиг тараасан. Учир нь үйлчилгээний хөлсөнд ноогдол ашигтай тэнцүү хэмжээний үйлчилгээний хөлс өгөх хэрэгтэй болсон.

Манай компанийн томоохон хувьцаа эзэмшигчдийг компанийн цахим хуудас дээр мэдээлэл байршуулсан байдаг. томоохон хувьцаа эзэмшигч нь 35%-г эзэлдэг.

Н.Бор санал

Анх хувьцаа гарч байхад хувьцааны талаар мэдээлэлгүй хувьцаа авсан тэгээд хувьцааны ханш дунд нь 200 төгрөг болж өсч байсан энэ үед яагаад ханш өссөн, одоо яагаад өсөхгүй байна вэ? Жижиг хувьцаа эзэмшигчид мэдээлэл муутай байна. Жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг ТУЗ-д оруулмаар байна гэсэн санал гаргаж байна.

Иргэн 3/ н.Хандмаа

Зардал ихэссэн байна. удирдлагын зардалын задаргааг тайлбарлаж өгөөч ер нь цалингийн дундаж хэмжээ хэд байгаа вэ? Хэдэн хүн ажиллаж байна.

Ерөнхий нягтлан Н.Уранчимэг

Манай компани улирлын чанартай зундаа гэрээт ажилтан авч ажиллуулдаг дунджаар 80 гаруй ажилтан ажилладаг. Цалингийн дундаж хэмжээ 550-580 мянган төгрөг байдаг. Зардалын дэлгэрэнгүй та бүхний тараах материал дээр байгаа.

Иргэн4/ н. Гансүх

Санал хэлмээр байна.Гэр баазын бохирын суваг үүдтэйгээ хэтэрхий ойрхон байна ашиглалтанд орж хүлээлгэж өгөхөөсөө өмнө зүүн тийшээ далдлах маягтай тавиарай.

Гүйцэтгэх захирал Б.Намуун

Санал хүлээж авлаа, ашиглалтанд орж дууссаны дараа өнгөц байдлууд бүгд далд орох юмаа.

Иргэн5/ Дамдин сүрэн санал

Компанийн засаглал ямар байгаа вэ? Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хэрхэн хангасан байгаа вэ? Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах хэрэгтэй гэж бодож байна. Аялал жуулчлалын салбар нэмэгдэж байгаа учир яаж өсөн дэвших алсын хараагаа сайн анхаарах хэрэгтэй.

Гүйцэтгэх захирал Б.Намуун

Саналыг хүлээн авлаа. ТУЗ-н хараат бүс гишүүд нь хувьцаа эзэмшигчдийн эрх үүргийг төлөөлж хангахаар ажиллаж байдаг. Аялал жуулчлалын салбарыг засгийн газраас чиг үүргийн салбар болгосон нь бидний эрхэм зорилго биелэлээ олоход 1 алхам урагшилж байгаагийн илрэл Тиймээс бид илүү өргөн цар хүрээтэй төлөвлөгөөтэй ажиллахаар төлөвлөж байна.

Иргэн 6/ Түяа

Зээл авсан, үүний оронд нэмэлт хувьцаа гаргах талаар судалсануу?

Женко олон спорт болон бусад арга хэмжээнд хандив өгч байна үүнд хэдэн хувийг зарцуулж байна.

1дох Асуултанд хариулая Д.Даянбилгүүн

Халаасны хувьцааг сэргээх талаар судалсан гэвч хуулиараа нэрэлсэн үнээс доогуур зах зээлд борлуулахыг хориглодог учир боломжгүй болоод байгаа.

2дох Асуултанд хариулая Ерөнхий нягтлан Н.Уранчимэг

Женко түр бюро ХК ямар нэгэн спорт бусад арга хэмжээнд хандив өгч байсан удаагүй. Та бүхэн зар сурталчилгаа болон хандив тусламжийг салгаж ойлгоно гэж найдаж байна. Аялал, үйлчилгээ, цогцолбороо сурталчилах үүднээс телевизийн нэвтрүүлэгтэй хамтран ажиллаж байгаа. Энэ нь өөр асуудал гэдгийг ойлгож байгаа байх бусад хэлбэрээр ямар нэгэн спортыг санхүүжүүлдэггүй энэ ташаа ойлголтыг залруулж ойлгоно гэж найдаж байна. Бид үйлчилгээ болон аялалаараа борлуулалтаа бүрдүүлж мөн тэрнь үйлчилгээ аялал, идэвхижүүлэлт, цалингийн зардалд гардаг байгаа

Иргэн2/ н. Дуламжав

Дүгнэлт санал хэлэх гэсэн юм

Хувьцаа эзэмшигчид хуралдаа хариуцлагатай оролцмоор байна. Женко тур аа дэмжмээр байна. Эдийн засгийн ийм хүндрэлтэй үед Гүйцэтгэх захирал харинч сайн ажилласан гэж дүгнэж байна, Мөн ирээдүйн сайн удирдагч болно гэдэгт итгэлтэй байна, та бүхний цаашдын ажилд амжилт хүсч байна.

Хурлын дарга Б.Лхагвадорж

Бусад хувьцаа эзэмшигчид санал аа бичгээр өгнө үү шаардлагатай асуудлуудыг дүгнэж хариу өгөх болно. Одоо тооллогын комиссын нэгтгэсэн дүнг танилцуулая

“Женко Түр Бюро” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нийт хувьцааны 74.65 хувь буюу 59,710,914 ширхэг хувьцаа эзэмшиж буй 150 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэй хуралдлаа.

Саналын хуудсаар дараах асуудлуудыг шийдвэрлэн санал хураасан:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн, батлах,
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн, батлах,
3. Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай,
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай,

Нийт ирсэн саналын хуудсыг үндэслэн дараах шийдвэр гарав:

Тооллогод нийт хувьцаа эзэмшигчдийн 74.65 % буюу 59,710,914 ширхэг хувьцаа эзэмшиж буй 150 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас ирснээс 71 нь хүчинтэй байлаа.

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн 88.51 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 11.49 % нь түдгэлзсэн байна.
2. Компанийн аудитын хорооны тайланг хувьцаа эзэмшигчдийн 88.51 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 11.49 % нь түдгэлзсэн байна.
3. Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчдийн 88.49% нь зөвшөөрсөн, 11.49 % нь татгалзсан , 0.02 % нь түдгэлзсэн байна.
4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал: Кумулятив аргаар санал өгөх хувьцааны тоо: 537,398,226 Тооллогод нийт хувьцаа эзэмшигчдийн 74.65 % буюу 59,710,914 ширхэг хувьцаа эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийн 150 саналын хуудас ирсэнээс 71 нь хүчинтэй байлаа.

Ердийн гишүүдэд:

	Нэр	Саналын хувь
1	Ч.Уламбаяр	7.64%
2	Х.Цэндбаяр	7.64%
3	Ц.Энхтүяа	7.64%
4	Д.Даваасүрэн	19.13%
5	Б.Батбаатар	50.30%
6	Б.Намуун	7.64%

Хараат бус гишүүдэд:

	Нэр	Саналын хувь
1	Д.Даянбилгүүн	33.33%
2	Б.Лхагвадорж	33.33%
3	Ж.Баттөр	33.33%

тус тус санал авч, ТУЗ-ийн гишүүд сонгогдов.

Та бүхэнд асуух асуулт байхгүй бол манай зүгээс бэлдсэн хоол болон үүх зүйлийг зооглоно үү? Баярлалаа

Хурлын дарга

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга



Б.Лхагвадорж

Б. Жавхаа